

Улаанбаатар хот дахь ХБИ-ийн нийгмийн оролцоог дэмжих төсөл (JICA/DPUB)

Мэдээллийн эмхэтгэл No27 2019.05



Холидэй Инн зочид буудал дээр “Үйлчилгээг сайжруулах сургалт” зохион байгууллаа (2019.05.07)

Холидэй Инн зочид буудал дээр Хөгжлийн бэрхшээлийн тухай сургалт зохион байгуулав. Сургалтанд фронт оффис, ресторан, өрөө үйлчилгээ, инженер, хүний нөөц, захиргаа, борлуулалтын алба зэрэг бүх хэлтсийн төлөөлөл хамрагдлаа. 2 өдрийн сургалтанд нийт 62 хүн хамрагдсан. Үдээс өмнө нь хөгжлийн бэрхшээлийн талаар ойлголт өгөх Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалт (DET) орсон бол үдээс хойш нь Үйлчилгээ, туслалцаа үзүүлэх аргачлалын талаар заав. Ингэхдээ хараа, сонсгол, хөдөлгөөн гэсэн 3 төрлийн бие эрхтний бэрхшээлийн талаар, мөн туслах аргачлалтай холбоотой практик сургалт хийлээ. Оролцогчид “Яг өөрөө тэргэнцэр дээр суугаад явахаар хүнд хаалгыг онгойлгох боломжгүй байна” “Үүдний хэсэгт налуу зам байгаа боловч ойролцоо нь машин зогсоочихсон байгаа учраас ашиглах боломжгүй байна”



Сургалтын үеэр

зэргээр шинэ асуудлуудыг ч анзаарч харж байв. Мөн орчноо сайжруулах тал дээр илүү хүчин чармайлт гаргах болно хэмээн өөрсдийн сэтгэгдлийг хуваалцах хүмүүс олон байлаа. Сургалтанд шөнийн ээлжинд ажилласан хүмүүс ч хамрагдсан бөгөөд бүгд сургалт дуустал идэвхтэй оролцож байлаа. Цаашид Илүү хүртээмжтэй зочид буудлыг бий болгохыг зорилт болгон хамтдаа хичээцгээе.

2019 оны "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал" Мэдээллийн лавлах ном хэвлэгдэн гарлаа. (2019.04.29)



ХНХЯ-аас Мэдээллийн лавлах номын 2-р цувралыг бэлтгэн гаргалаа. DPUB төсөл тус номыг бэлтгэн гаргахад хамтран ажиллав. Мөн япон хэлээр ч хэвлэсэн байгаа бөгөөд ойрын хугацаанд англи хэлээрх номыг гаргахаар ажиллаж байна. 2-р цувралын онцлох агуулга нь 9-р бүлэгт байгаа "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөлүүд"-ийн ажлын тайлан болон 1-р бүлэгт нийтлэгдсэн "Онцлох сэдэв" юм. Уг номыг хүртээмжтэй байдлаар ХНХЯ-ны цахим хуудсанд байршуулах төлөвлөгөөтэй байгаа бөгөөд тухайн үед нь та бүхэнд мэдээлэл хүргэх болно. DPUB төслийн зүгээс Хөгжлийн бэрхшээлийн салбарын үндсэн мэдээллийг нэгтгэсэн тус "Мэдээллийн лавлах ном"-ыг цаашид жил бүр хэвлэх ажлыг дэмжин ажиллах болно.

Багануур дүүргийн үйл ажиллагаа: Дүүргийн бодлого чиглэл (2019.04.19)



Уулзалтын үеэр

Багануур дүүргийнхэн Засаг даргынхаа удирдлаган доор хөгжлийн бэрхшээлийн асуудлыг шийдвэрлэх үйл ажиллагаануудыг явуулж байна. Анх 2017 онд DPUB төсөл Багануур дүүрэгт Хүртээмжийг сайжруулах, Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалт (DET) гээд бүтэн өдрийн сургалт хийсэн ба Засаг дарга болон төр, хувийн хэвшлийн 80 орчим удирдах ажилтан оролцсон. Энэ удаагийн уулзалтын үеэр Засаг дарга Ц.Сандаг-Очир “Зөвхөн төрийн алба төдийгүй үйлчилгээний салбарын хүмүүстэй хамтраад барилга байгууламжийн саадыг арилгах чиглэлээр ажиллаж байна” гэж байлаа. Мөн зураг төслийн шатанд нь хүртээмжийг тусгаж өгөх шаардлагатай учраас барилгын салбарынханд зориулж хөгжлийн бэрхшээлийн тухай ойлголт өгөх, хүртээмжийг сайжруулах сургалт явуулах нь зүйтэй гэх мэт саналуудыг ч хэлж байв. Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга Г.Гэрэлмаа энэ жилийн 1-р сард зохион байгуулагдсан Япон дахь сургалтанд оролцсон. Улмаар сургалтаас сурч мэдсэн зүйлээ хэрэгжүүлэхийн тулд дүүрэгтээ тайлангийн хурал зохион байгуулжээ. Эхний ээлжинд дүүргийн Засаг даргын Тамгын газрын байр, ойр орчмынхоо хүртээмжийг сайжруулах чиглэлээр ажиллах болно гэж байлаа.

Сонсголын бэрхшээлтэй иргэдийн хамтын ажиллагааг бэхжүүлэхэд юу шаардлагатай вэ? (2019.04.24)

Дээрх сэдвээр DPUB төслийн зүгээс Санал солилцох уулзалт зохион байгууллаа. Бусад улсын жишээнээс харсан ч хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ТББ-уудын хамтын ажиллагаа сайн байгаа орнуудад ХБИ-ийн нийгмийн халамжийн бодлого хөгжиж, тийм биш орнуудад хангалтгүй байдаг. Хамтын ажиллагаа чухал гэдгийг холбогдох хүмүүс ойлгож байгаа ч хамтран ажиллах нь тийм ч амар зүйл биш. Үүний шалтгаан нь юу вэ? Харилцаа холбоо дутмаг, өөрийн эрх ашгийг нэн түрүүнд тавих, манлайлагч байхгүй, ерөнхий үндсэн ойлголтууд хангалтгүй, санал нэгдэхгүй байх гэх мэт янз бүрийн шалтгаануудыг дурдаж байв. Тэгвэл эдгээрийг хэрхэн шийдвэрлэх вэ? Ярилцах, харилцан ойлголтоо бэхжүүлэх, байгууллага бий болгох, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, манлайлагч бэлтгэх гэх мэт олон янзын гаргалгааг ярьж байлаа. Тайланд дахь сургалтаас “Нийтийн эрх ашгийг тодорхой болгох” тухай суралцсан. Сонсголын бэрхшээлтэй иргэд зөвхөн дохионы хэлийг, харааны бэрхшээлтэй иргэд брайль үсгийг, хөдөлгөөний бэрхшээлтэй



Сонсголын бэрхшээлтэй олон хүн оролцлоо

иргэд туслах ажилтан л шаардлагатай гээд байх юм бол бүх хүмүүсийн санал зөрөлдөнө. Харин Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих тотолцоо шаардлагатай гэж үзвэл хамтран ажиллаж чадах юм. Тайландад ийм арга замаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ТББ-ууд ижил зорилгоо

тодорхой болгон Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тухай хууль, Боловсролын хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хуулийг батлуулах үйл ажиллагаануудыг явуулж ирсэн. Үүнд мэдээжийн хэрэг зохицуулалт чухал. Энэ тохиолдолд ямагт урд нь явдаг манлайлагч бус зохион байгуулалт хийх чадвартай манлайлагч шаардлагатай. Өөрийн саналыг бус бүх хүмүүсийн саналыг тусган нэгтгэх ажлыг олон удаагийн давтамжтайгаар хүчин чармайлт гарган хийснээр Тайландад Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зөвлөл амжилттай ажиллаж иржээ. Тайландад амжилттай хэрэгжсэн зүйл Монголд хэрэгжих бүрэн боломжтой. Гэхдээ цаашдын үйл ажиллагаа чухал. Юуны өмнө сонсголын бэрхшээлтэй иргэдийн нийтийн эрх ашиг болох “дохионы хэл, үсэгт тайлбартай телевизийн нэвтрүүлэг”-ийг Монголд хэрэгжүүлэхийг хүсэж байна. Ийм зорилгыг дэвшүүлэн 1 дэх удаагийн санал солилцох уулзалтыг өндөрлөлөө. Дараагийн удаа 5-р сард Мэдээллийн хүртээмжийн семинарыг зохион байгуулж, дохионы хэл, үсэгт тайлбартай телевизийн нэвтрүүлгийн талаар хэлэлцүүлэг өрнүүлнэ. Сонсголын бэрхшээлтэй иргэд маань цаашид амжилттай хамтран ажиллана гэдэгт итгэлтэй байна.

JICA DPUB фэйсбүүк хуудсанд LIKE дарж нэгдээрэй!!

Төслийн фэйсбүүк хуудсанд LIKE дарсан нийт хүний тоо **4966** болж, маш олон хүнд төслийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл хүрэх боллоо. Цаашид ч гэсэн олон сонирхолтой мэдээллүүдийг та бүхэнд хүргэхийн тулд хичээн ажиллах болно.

<https://www.facebook.com/jicadpub/>

DPUB連絡先

Office: Government Building – 2, United Nation’s Street – 5, Ministry of Labor and Social Protection Ulaanbaatar – 15160, Mongolia

Facebook: <https://www.facebook.com/jicadpub>

Website: <https://www.jica.go.jp/project/mongolia/015/index.html>

E-mail: dpub.jica@gmail.com

Мэдээллийн хүртээмж хэмээх ажил



Ахлах зөвлөх Чуба

2000-аад оны эхээр хөгжиж буй орнуудад ч интернет дэлгэрч эхэлсэн хэдий ч бодит байдал дээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн олонх нь мэдээлэл гэдэг зүйлээс хол байлаа. Хөгжиж буй орнууд болон өндөр хөгжилтэй орнуудын хооронд мэдээллийн ялгаатай байдал нэлээд их байв. Яг тухайн үед Ази, Номхон далайн бүсийн хөгжиж буй оронд томилогдон очиж, ХБИ-ийн компьютерийн хэрэглээг судлах ажлыг хариуцах болсон. Ихэнх хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ТББ-ууд компьютер худалдан авах мөнгөгүй, интернетийг тэр бүр ашигладаггүй нөхцөл байдалтай байсан боловч нөгөөтэйгүүр компьютер ашиглах сонирхол ихтэй байв. Компьютертой болчихвол ажил, амьдралд ихээхэн нэмэртэй...гэх хүмүүс олон байсан. Гэхдээ APCD нь компьютер тараадаг байгууллага биш. ЖАЙКА-ийн Техникийн хамтын ажиллагааны төсөл нь хүний нөөцийг чадавхжуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Иймд APCD цахим хуудасны хүртээмжтэй байдлыг сайжруулах, аудио ном хийх, дэлгэрүүлэх, компьютерийн дэмжих хэрэгслийн хэрэглээг нэмэгдүүлэх зэрэг сургалтуудыг зохион байгуулахаар болсон. Миний хувьд эдгээр ажлуудыг анх удаа хариуцаж байсан учраас Кавамүра багшаас зөвлөгөө авангаа бэлтгэл ажлуудыг явуулж байв. Энэ үед Ази, Номхон далайн бүсийн орнуудаас олон хүмүүсийг урилгаар сургалтанд хамруулж байсан учраас миний танилын хүрээ өргөжихийн сацуу хөгжлийн бэрхшээл, мэдээлэл технологийн талаарх илүү сайн мэдлэгтэй болж байлаа.